

СУРВАЛЖААР ТОДРУУЛСАН ТЭМҮЖИНИЙ БАГА, ЗАЛУУ НАС
Тэмүжиний удам

Ш. Чоймаа*

Өнгө чанар нь үл хувирах алтаар аливаа эрхэм дээд зүйлээ адилтган нэрлэх ёс бол монголчуудын хэл сэтгэлгээний эртний онцлог юм. “Монголын Нууц Товчоон”-д “*alt* (*alta-altan*)” хэмээх үг хүний нэр цолын бүрэлдэхүүн болж орсноос гадна, 33 удаа тохиолдоно. Үүнд, эдлэл хэрэгслийн нэрээр 11 удаа, өргөл бэлэг, олз татварын зүйлээр 14 удаа гарахаас гадна, алтаар зүйрлэж өгүүлсэн нь 8 удаа тэмдэглэгджээ. Бидний сонирхож байгаа нь алтаар зүйрлэсэн жишээ баримт бөгөөд “*алтан амь*”, “*алтан босго*”, “*алтан аргамж*”, “*алтан жолоо*”, “*алтан бие*”¹ гэх мэт буй. Мөн XVII зууны монгол түүхэн сурвалж Лувсанданзаны “*Алтан товч*”, Тэмгэгийн 1925 онд хэвлүүлсэн “*Чингис хааны үздиг*” хоёроор уламжилсан Чингис хааны нэгэн билиг сургаалын дотор “*Алтан биеэ амусу (амсхийе, Ш.Ч) хэмээвээс, аху (оршихуй, Ш.Ч) төр минь алдруузай*” хэмээх алдарт үгэнд “*Алтан бие*” хэмээн өгүүлсэн байдаг. “*Алтан биес*”-ийн “*алтан аргамж*” болсон уг удмын хэлхээ холбоог мөн л “*алтан ураг*” хэмээнэ.

Эзэн богд Чингис хаантны намтрыг өгүүлэх хэмээвээс, уг удмын буюу алтан ургийн хэлхээг бидэнд уламжилсан баримт сурвалжид түшин бичих нь монгол түүх бичлэгийн ёсонд нийцэх билээ. “Монголын Нууц Товчоо”-ны эхэн хэсэг буюу “*Чингис хааны узуур*” хэмээх гарчигтай зүйл анги бол үнэндээ угийн бичээс байдаг юм.

Монголчуудын эрт цагаас уламжилж ирсэн хүнийг шинжих, хүний ирээдүйг зөгнөн харах гол хэмжүүрийн нэг бол уг удам нь ямар хүмүүс байсан бэ? гэдгийг юун түрүүнд авч үздэг явдал юм. Монгол ардын зүйр цэцэн үгэнд “*Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг*” гэсэн үг бий. Энэ нь эцэг, эхийн ямар нэг шинж заавал ч үгүй үр удамд удамшдаг гэдгийг хэлж байгаа хэрэг.

Монголчууд уг удмыг нэн чухалчилдаг тул өөрийн үр хүүхдүүдээ өвөг дээдсийнхээ үе залгамж, тэдний салаа салбарыг бага насанд нь цээжлүүлж, бас “*угийн бичиг*” хөтлүүлдэг байсан билээ. Энэ нь ураг барилдахад тун чухал нөлөөтэй байлаа.

* МУИС-ийн МХСС-ийн багш, ШУ-ны доктор, профессор

¹ 1362 оны “*Индүвангийн хөшөөний монгол бичээс*”-т “*Чингис хаан тэнгэрийн зоригийг даган, үмэд (умар) газраас их үйлийг бүтээн, алтан биеэр улс хаман аялан явсан дөтгээс, санд ...*” хэмээн гардаг.

Одоо ч хүртэл монголчууд хүүгээ гэрлүүлэх, хүүхнээ нөхөрт гаргахдаа, хоёр талын уг удмыг судалж мэдэхийг нэн тэргүүнд зорьдог.

Монголчуудын хүнийг шинжлэх, уламжлалт ёс заншлын дагуу Чингис хааны уг удмыг Монголын Нууц Товчоон²-д дурдсанаар жагсаан үзье.

I үе	Бөртэ чоно, Хуа марал	Börte cino, Qo'ai maral
II үе	Батачихан	Batacihan
III үе	Тамача	Tamaca
IV үе	Хоричар мэргэн	Qoricar mergen
V үе	Агужам борохул	A'ujam boro'ul
VI үе	Сали Хачагу	Sali Qaca'u
VII үе	Их нүдэн	Yeke nidun
VIII үе	Сэм сочи	Sem soci
IX үе	Харчу	Qarcu
X үе	Боржигидай мэргэн	Borjigidai mergen
XI үе	Торголжин баян	Torqoljin bayan
XII үе	Тэнгэр, түүний гэрлээс жирэмсэлсэн Алан гуа	(Tngri) Alan qo'a
XIII үе	Бодунчар	Boduncar
XIV үе	Хабичи баатар	Qabici ba'atur
XV үе	Мэнэн tudun	Menen tudun
XVI үе	Хачи хүлүг	Qaci kulug
XVII үе	Хайду	Qaidu
XVIII үе	Байшинхор догшин	Bai-sinqor-doqsin
XIX үе	Тумбинай цэцэн	Tumbinai secen
XX үе	Хабул хаан	Qabul qa'an
XXI үе	Бартан баатар	Bartan ba'atur
XXII үе	Есүхэй баатар	Yesugei ba'atur

Монголын Нууц Товчоон тэргүүтэй түүхэн сурвалж бичгүүдэд тогтвортой тэмдэглэн бичиж ирсэн Чингис хааны өвөг дээдсийн эдгээр 22 үеийн хүмүүсийн нэрэнд “мэргэн”, “сэцэн”, “хүлүг”³, “баатар” гэх мэт алдар цолыг заасан үгс, тухайн хүний оноосон нэрийн бүрэлдэхүүн болж байгааг анхаарах ёстой. Энэ нь Чингис хааны өвөг дээдэс бол тал нутагт алдар нь түгсэн дайчин баатар, мэргэн сэцэн эзэд байсныг баталж байна.

Тэмүжиний эцэг Есүхэй баатарын тухай олныг өгүүлж болох бөгөөд Рашид-ад-дин бээр “Судрын чуулган”-даа “Есүхэй баатар бол Чингис хааны эцэг нь билээ. Тэрбээр олонхи олон аймгийн эзэнтэн байв. Түүний их бага төрөл, өөрөөр хэлбэл, өвөг эцэг ба үеэл ах дүү нар нь Есүхэйг дотроосоо нэгэн дуугаар хан болгоод дуулгавартай захирагддаг байв. Тэрбээр эрэлхэг бөгөөд зоригтны тоонд ордог байв.

² Rachewiltz Igor de (1972), *Index to the Secret History of the Mongols*, Bloomington.

³ “хүлүг” хэмээх үг нь “алдартай”, “чуутай” гэсэн утгатай нийт алтай хэлний үг. Энэ үгийн тухай Ш. Чоймаа “Монголын Нууц Товчоон-д гарах ‘küllüg’ хэмээх үгийн утга, гарал, хувьсал” гэсэн илтгэлийг ОУМЭ-ийн VII Их Хуралд тавьсан болно.

Есүхэй баатар бусад монгол аймагтай олонтой байлдаж тулалдаж байсан бөгөөд тухайлбал, татар аймаг, мөн хятадын (Алтан улсын) цэргүүд ба ноёдтой тулалдсаар байжээ. Түүний тухай чимээ орчин тойрондоо түгээж, нэр нь алдаршин, тэрбээр бүгдэд хүндлэгдэн дээдлэгдэх боллоо"⁴ хэмээснийг эш татаад бусдыг товчлов.

Чингис хэмээх бие хүн төлөвшин нийгэмшихэд өвөг дээдсийн яруу алдар, уг удмын дайчин шинж чанар нь дараах нөлөөг үзүүлсэн гэж болно.

1. Төв Азийн өндөрлөгт, эрс тэс уур амьсгалтай газар нутагт, байгаль дэлхийтэйгээ хамгийн ойр амьдарч ирсэн монгол язгуурын хүний хувьд бусад монгол хүмүүстэй адил төстэй удамшлын нийтлэг гинж (ген) агуулж байсан нь магад юм. Нөгөө талаас, Тэмүжинд өвөг дээдсийн “мэргэн”, “сэцэн”, “баатар” шинж хувь хүний тухайд удамшсан нь мэдээж билээ.
2. Өвөг дээдсийн удмын сайн нэр, алдар гавьяа нь Тэмүжинийг (Чингис хааныг) үхэх аюулаас ч гэтэлгэж байсан гэж болно. Тухайлбал, Тайчуудын Таргудай Хирилтүг Тэмүжинийг гэнэт довтолж, аваачаад дөнгөлж, айл айл хэсүүлэн байх үес Сорхан Шар болон түүний хүүхдүүд оргуулан явуулдаг. Энэ нь нэг талаар эцэг Есүхэй баатрыг хүндэлдгийн хувьд, нөгөө талаар Тэмүжинийг эцэг шигээ сайн эр болохыг тодорхой мэдсэний учир юм. Энэ үйл явдлын дүнд, Сорхан Шар Тэмүжинийг эрж явах үедээ, Онон мөрний харигт гэдрэг харж хэвтээд, дөнгөө ус руу урсган, нүүрээ ил гарган хэвтэж буй Тэмүжинтэй таарч “Ийм аргатын тул “нүдэндээн галт, нүүрэндээн гэрэт (гэрэлт)” хэмээн Тайчууд ах дүүдээн тийн л атаархагдан ажгуу, чи. Тийнхүү хэвт. Үл заах би”⁵ гэж хэлсэн нь өмнө өгүүлсэн санааг баталж байгаа юм.
3. Монголчууд “ганц мод гал болдоггүй, ганц хүн хүн болдоггүй” гэж хэлдэг. Энэ нь ганц хувь хүн бол юуг ч хийж чадахгүй, заавал хань нөхөд хэрэгтэй гэсэн үг. Есүхэй баатар нас барсны дараа эцгийн их хүрээ буудалд, 9 настай өнчрөн гээгдэж хоцорсон Тэмүжин хүү хүнд хэцүү аюул зовлонг туулан байж өсөн өндийх цаг үеэс Их Монгол Улсыг байгуулах хүртэлх урт хугацаанд түүнтэй нөхөрлөхөөр ирэгсдийг дуудан далласан нэгэн далд хүч бол сайн эцгийн алдар гавьяа байсан юм. Өөрөөр хэлбэл, Тэмүжинийг эцэг шигээ дайчин баатар, Хамаг Монголын эзэн болно гэдэгт итгэсэн хэрэг юм.
4. Тэмүжиний өвөг дээдсийн алдар нэр, эцэг Есүхэйн баатарлаг үйлс нь Тэмүжинд даган орогчдыг даллан дуудах сайн талтай байсны хамт, эсрэгээр даран сөнөөх санаатныг бүрдүүлж байв. “Барсын зулзагыг бага дээр нь” гэдэг үзлийг баримталж, Тэмүжинийг хүчирхэг болохоос нь өмнө мөхөөхгүй бол тун хурдан

⁴ Рашид-ад-дин, *Судрын чуулган*, I боть, II дэвтэр, орчуулсан Ц.Сүрэнхорлоо (2002), 201-202 тал. Улаанбаатар.

⁵ Ш.Чоймаа (2011), *Монголын Нууц Товчоон эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*, (*Шинээр хөрвүүлж, тайлбар үйлдсэн*), 40-41-р тал. Улаанбаатар.

хүчирхэгжиж буй түүнийг хожим яагаад ч дийлэхгүй гэдгийг ухаарагчид олон байсан билээ. Энэ нь Тэмүжинийг хүсээгүй тэмцэл, хүлцэнгүй тулаанд татан оруулж байв.

5. Тэмүжин бээр өшил хяслын дундуур, үхэл сэхлийн заагаар хатуу зориг, хурц ухаан, зөв мэргэн шийдлийг гарган тэмцсээр уг удмынхаа алдар нэрийг мандуулж *“сайн хүний үр, сүүт гүүний унага”* болохоо нэгэн насныхаа амьдралаар харуулж чадсан.

Тэмүжин мэндэлсэн тухайд

Боржигин овогт Хиад яст эзэн богд Чингис хаантны багын нэр Тэмүжин. Тэрбээр хар морин жил (1162)-ийн өвлийн тэргүүн сарын шинийн нэгнээ, Хан Хэнтийн Дэлүүн болдог хэмээх газарт Өгээлүн эхээс мэндлэх яг тэр мөч нь, эцэг Есүхэй баатар бээр өвөг дээдсийн өстөн хястан Татаартай хатгалдан дийлээд, дайсны тэргүүн баатадыг олзлон, ялалтын тугаа мандуулсаар эгэн ирээд, дөрөө мултлах агшинтай давхацан тохиосон ажээ. Энэ нь санаандгүй байдаг л нэгэн тохиол учрал бус, Тэмүжин хөвүүний ирээдүйн хувь тавилан, заяа төөргийн зөн бэлгэдэл мөн байсан билээ.

“МНТ”-д *“Тэнд Есүхэй баатар Татаарын Тэмүжин Үгэ, Хори Буха тэргүүтэн Татаарыг дагуулиж ирвээс, тэнд Өгээлүн үжин хээлтэй бүрүүн (жирэмсэн байсан тул) Ононы Дэлүүн болдогоо бүхүйд, зөв тэнд Чингис хаан төржүхүй. Төрөхүйд, баруун гартаан шаан (шагайн) төдий нөжин атган төржүхүй. Татаарын Тэмүжин Үгэ-г авч ирсэнд төрөв хэмээн Тэмүжин нэр өгөхүй тийм”*⁶ хэмээн бичсэн буй. Энэхүү товчхон өгүүлсэн хэсэг нь олон зүйлийг тодотгох боломж олгодог. Дундад зууны үеийн Төв Азийн элгэнд оршиж, эсрэгцэн тэмцэлдэж, эв эеэ эс олсон олон монгол омогтныг атгасан шагай шиг гартаа оруулж, нийт эсгий туургатныг шударгатган төвхнүүлэх хувь төгс төөрөгтэй төрсөн Тэмүжин хөвүүний мэндэлсэн улирлыг энэ л хэсгээс эрж болно. Тухайлбал, өвөг дээдсийг нь барсан өстөн Татаарыг Есүхэй баатар дайлаад, ялан дийлж ирсэн цаг мөч мөн тул, яах аргагүй *“агт таргалсан нум хатуурсан”* намрын адаг, өвлийн эхэн сар болох нь тодорч, цөөнгүй түүхэн баримтаар нутлагддаг өвлийн эхэн сарын шинийн нэгэнд Тэмүжин хөвүүн мэндэлжээ хэмээн товлон тогтоож болох аж⁷. *“Гарсан өдрийн гараг, төрсөн өдрийн төөрөг”* гэдэг нь суут их хүмүүнд байтугай эгэл жирийн хэн бүхэнд ч эрхэмлэх зүйлийн нэг мөн билээ. Их эзэн Чингис хааны мэндэлсэн, Их Монгол улсын хаан болсон, тэнгэрт хальсан гурван чухал он жилийг судлаачид сурвалж бичиг баримтад түшиглэн судалснаар, морин жил мэндэлж, бар жил 45 насандаа Их Монгол улсын хаан ор сууж, гахай жил тэнгэрт хальсан болох нь тодорхой болжээ. Мэндэлсэн он жилийн тухайд бичгийн сурвалжаас гадна, Монгол улсын Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Дуутын хар чулуунаа Цогт тайж бээр

⁶ Ш.Чоймаа (2011) Монголын Нууц Товчоон (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг), 25-р тал. Улаанбаатар.

⁷ Ш. Чоймаа (2007) Эзэн богд Чингис хааны мэндэлсэн он цагийг түүхэн сурвалжийн баримтаар нягтлах нь // *“Монголын Нууц Товчоон хийгээд монгол сурвалж бичгийн судлал”* (Монгол узуур соёлын цуврал), Өвөр Монголын хэвлэлийн Хороо. 256-272 талаас үзнэ үү. Хөххот.

1624 онд сийлүүлсэн бичээст: “Чингис хааны ур, Очир хааны ач, Халхын Цогт тайжийн зарлигаар. Дайчин хиа, Гүен баатар хоёр Монголын хутагт хааны учираа, Чингис хааныг төрсөн усан морин жил (1162)-ээс нааш 464 жил болсноо, жилийн эх модон хулгана жил, сарын эх гал барс сарын 15 их цагаан өдрөө хас эрдэнэ мэт хаданд бичив” хэмээсэн байдаг нь өнөөдөр ч тод томруун дурайн харагддаг. Энэ бол XVII зууны эхэн үеийн баттай баримтын нэг мөнөөс мөн.

Хар морин жилийн өвлийн тэргүүн сарын шинийн нэгнээ мэндэлсэн ууган хөвүүндээ, эцэг Есүхэй баатар бээр төмөр мэт бат бэх байхыг бэлгэдэхийн сацуу, Тэмүжин-үгэ шиг баатар эр болохыг ерөөж, Тэмүжин хэмээн нэрийдсэн ажгуу. Тэмүжин хөвүүн ч төмөр шиг чин бат, Тэмүжин-үгэ-ээс ч хэт дайчин эр, уудмыг агуулагч ухаалаг жанжин, улс түмнийг төвхнүүлэгч их хаантан болсон билээ.

Тэмүжин хөвүүн бээр тал хээрийн язгууртан баатрын хөвүүдийн өсч торниж, хүмүүжиж боловсордог тэр л мөр жамаар эр хүн болон өндийжээ. Тухайн үеийн Монголчуудын хөвгүүд хэрхэн хүмүүжин боловсордгийг, нүдээр үзэж, чихээр сонссон харийн элч төлөөлөгчийн тэмдэглэлээс бид мэдэж болно. Тухайлбал, өмнөд Сүн улсын элч Пэн Дая, Сюй Тин нарын бичсэн “Хар Татаарын хэргийн товч” (Хэйда шилуэ)-д “Тэд харвах намнахдаа нялх хүүхдээ өлгий хавтсан модонд хийн дээсэлж, мориндоо ганзагалаад, эхийг нь дагуулж явуулдаг юм. Гурван насны хүүхдээ эмээл дээрээ уяад, гарт нь цулбуур бариулан, олныг дагуулж давхиулдаг. Дорөв, таван насанд нь бага нум, охор сум бариулж оролдуулснаар жаахан өссөний хойно, жилийн дөрвөн улиралд ан ав хийхэд л явуулдаг”⁸ хэмээн бичсэн байх ба Ромын Папын элч Плано Карпини бээр 1247 онд бичсэн тайлан тэмдэглэл мэт зохиолдоо: “Эрчүүд нь нум сум, зэвсэг үйлдвэрлэж, мал сүргээ хааяа нэг харж, ан хийх, нум сумаар харвахаас өөр ямар ч ажил хийдэггүй. Тэд том жижиггүй сайн харваачид ба тэдний хүүхдүүд хоёр, гурван нас хүрэх үү үгүй юу морь унаж сураад томчуултай зэрэгцэн давхилдана. Хүүхдүүд тодорхой насанд хүрэхэд нум сумаар яаж харвах, ашиглах талаар заалгаад нэг нэг нумтай болж авдаг. Угаасаа тэд маш их шаламгай ба зоригтой билээ”⁹ хэмээн, Өмнөд Сүн улсын элчийн тэмдэглэлтэй тун төстэй зүйлийг бичжээ. Дорно, өрнийн элч төлөөлөгчийн үзэж мэдсэнээ тэмдэглэсэн эдгээр баримт нь нэг ёсондоо, Тэмүжиний нялх багын намтрын ерөнхий дүр төрх юм.

Баримтаар баталгаажуулсан бага насны дүр

Чингис хааны бага насны намтрыг түүхэн сурвалжид тэмдэглэн үлдсэн хэсэг бусад үг өгүүлбэрээс тодотгон үзэхээс өөр аргагүй юм. Юуны өмнө, монгол хүн, монгол газар, монгол бичгээр бараг тухайн цаг үед нь туурвисан МНТ-ыг нягтлан үзэх ёстой. Үүний тулд, МНТ-д Тэмүжиний бага настай холбогдсон үг өгүүлбэрийг тухайлан авч, тодотгон өгүүлэхийг хичээе.

⁸ Хэрээд Ж. Баясах (2005) *Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг*, 263-р тал. Улаанбаатар.

⁹ Плано Карпини (2006) *Монголчуудын түүх*, Итали хэлнээс орчуулсан Л. Нямаа, 27-р тал. Улаанбаатар.

Нэгэн зүйл: Тэмүжиний нялх багын байр байдлыг Өгээлүн эхээс өөр хэн сайн мэдэх билээ. МНТ-ны 244-р зүйлд, Тэв тэнгэр хэмээх Хөхөчү бөөгийн хатгаан үгэнд автаж, Чингис хаан бээр дүү Хасарыг баривчлан байцааж бүхүйд, Өгээлүн эх машид хилигнэж, шөнөжин явж очоод, Хасарыг суллан, хоёр хөхөө ил гарган "Үзэв үү? Хөхсөн хөх тану энэ буй... Тэмүжин энэ нэгэн хөхийг минү барах бүлгээ. Хачигун, Отчигин хоёулаа болж, нэгэн хөх үл барах бүлгээ. Хасар бүрүүн (болбоос) хоёр бүр хөх минү барж, цээж минү агуу болтол амарлиулж, цээж агуу болгох бүлгээ. Түүгээр, эрдэмт Тэмүжин минү цээж эрдэмт, Хасар минү хав хүч эрдэмт тул ..." ¹⁰ хэмээн өгүүлж, Чингис хааныг ичиж айтал зэмлэн хэлдэг. Хэдийгээр Өгээлүн эх Чингис хааныг буруутган загнаж, Хасарыг магтан өмөөрч байгаа зүйл боловч, тэр хоёрын нялх багын хүч тамир хийгээд эрдэм чадлыг нь өөрийн эрхгүй харьцуулан өгүүлсэн хэрэг юм. Өгээлүн эхийн дүгнэлтээр бол, хав хүч чадлын хувьд Хасарын хагаст, харин ухаан билиг, оюуны чадамжаар эрс өөр болохыг "цээж эрдэмт" хэмээн тодорхойлжээ.

Нэгэн зүйл: Чингисийн бага насны дүр байдлын тухай 62-р зүйлд Дэй сэцэн

"Энэ хөвүүн чинь

Нүдэндээн галт

Нүүрэндээн гэрэт(гэрэлт) хөвүүн буй" ¹¹

гэж хэлсэн байдаг. Есөн настай Тэмүжин хөвгүүнийг анх хараад ингэж хэлсэн нь түүний онцлог хувь шинжийг багцлан дүгнэсэн хэрэг юм. Тайчуудын Сорхон Шар бээр модон дөнгөтэй усны харигт биеэ нуун хэвтэж бүхүй Тэмүжин хөвгүүнийг олж хараад, Дэй сэцэнтэй адил үгийг хэлсэн байдаг.

Монголчуудын үзлээр бол эр хүний нүдэнд ухаан билиг, эр зориг, алсын хараа, зорьсноо биелүүлэх хүсэл зэрэг цөм тодорч байвал "нүдэндээ галтай" гэж хэлдэг. Тэмүжин үнэхээр "нүдэндээ галтай" хөвгүүн байсан билээ. Тэмүжин тэрхүү "галтай нүд"-ээрээ тухайн цаг үеийн талын нүүдэлчдийн догшин ширүүн тэмцэлт амьдралыг харж, ирээдүйн өөрийн зорилгоо эрс өөрөөр баримжаалах болов.

Нэгэн зүйл: Тэмүжинийг 9 настай өнчрөн хоцроход, эцэг Есүхэй баатрын харьяат иргэдийн толгойлогч нар, тухайлбал, Төдөгэн Гиртэ бээр

"Цээл усан нядарлаа (масарлаа)

Цэгээн чулуу цуурлаа" ¹²

хэмээж хэлээд, өнчин дүү нарыг нь, бэлбэсэн эхтэй нь хамт нутаг дээр хаяж нүүн одоход тэрбээр уйлан хоцорсон тухай МНТ-д өгүүлдэг.

¹⁰ Ш.Чоймаа (2011) *Монголын Нууц Товчоон (Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг)*, 202-р тал. Улаанбаатар.

¹¹ Мөн тэнд, 26-р тал.

¹² Мөн тэнд, 33-р тал.

Монголын Нууц Товчооны ихэнх хэсгийг агуулсан XVII зууны Монгол түүхийн сурвалж бичиг Лувсанданзаны Алтан товчид энэ үйл явдалтай холбоотой нэгэн сонин мэдээ баримт бий.

Тэмүжин эцгээ нас барсанд гашуудан “... газарт уруу унан хэвтэж, маш гаслахуйд Хонхотаны Чирха сэрээн өгүүлсэн ажгуу.

“Тул загас мэт яахин

Тулбиран гасалмуй чи.

Туурга цэргээ бэхэлье, эсхүү хэмээлдлээ юу

Лагар загас мэт яахин

Лайбаран гасалмуй чи.

Нармай улсаа байгуулахуй эсхүү хэмээлдлээ юу” хэмээн өгүүлбээс, хайлахаа устсан ажгуу”¹³ гэж гардаг.

Чи ийм сул дорой, сэтгэлийн тэвчээргүй байвал, улс орноо хэрхэн аврах вэ хэмээсэн утгатай Хонхотаны Чирха өвгөний үг, уснаас хагацсан загас шиг газарт хөлбөрөн гаслан уйлж байсан Тэмүжин хөвгүүнийг шууд сэрээж чадсан юм. Энэ нь Тэмүжинд Хамаг Монголын хувь заяа шууд хамаатайг ойлгуулсан хэрэг байсан юм.

Овог аймгууд дайсангасан энэ үеэс Тэмүжин ууган хүүгийн хувьд дэндүү хүнд ачааг үүрч, бас олон дайсны нүдэнд ямагт өртөх болжээ. Төвөгтэй байдал буй болоход эрс зоримог шийдэж, хожмын үйл, хойчийн тусын тул хатуу догшин үйлийг ч хийх зориг зүрхтэй байх ёстойг ч ойлгожээ. Үүний нэгэн баримт нь эцэг нэг, эх өөр Бэгтэрийг, Тэмүжин бээр Хасартай нийлэн харваж алсан гунигт хэрэг юм. Судлаачид үүнийг гол төлөв Тэмүжиний харгис догшин ааш араншинтай байсны баримт болгодог. Харин түүхч П. Рачневский¹⁴ түүхч А. Гумилев¹⁵, нарын тайлбар үнэнд ойр юм. Бэгтэр Тайчуудтай далдуур холбоотой байж, улмаар ах дүүсийн хооронд эвийг эвдэж, өрх гэрийн толгойлогч ч болох хүсэлтэй болох нь Тэмүжинд нэгэнтээ мэдэгдсэн тул тийм хатуу шийдэлд хүрэхээс өөр аргагүй байжээ. Гэвч энэ явдлаас хойш Тэмүжиний дүү нар нэгэн эвтэй, нэгдмэл зорилготон болсон билээ. Харгис хатуу ч гэсэн, тухайн нөхцөл байдалд хожмоо аварсан ийм үйлдэл хийх нь гарцаагүй зөв хэрэг байсан юм. Өүлүн эхийн хатуу чанга зэмлэлийг ч хүлээсэн.

Энэ үеэс “хоёр хүн эвтэй бөгөөс төмөр хүрээ мэт бэх, хорин хүн эвгүй бөгөөс эвдэрхий хүрээ мэт хэврэг” гэсэн үзэл нь туйлбартай болж, дайсныг ялахад өөр зуураа эв эетэй байж, эв эеийг эвдсэн хэнийг ч болов үл өршөөх ёс журмыг насан туршдаа хатуу баримталсан билээ.

Нэгэн зүйл: Судлаачид “Мау Өндөрийн байлдаан” хэмээн нэрлэдэг Ван хантай эрэгчин эмэгчнээ үзэлцэх том тулаан “Чингис хааны товчоон”-ыг туурвисан Сайшаал гуайн бичсэнээр 1203 оны хавар зуны хооронд болжээ. Энэ удаагийн хатгалдаанд Чингис хаан цөөн цэргээр олон дайсныг дийлсэн боловч өөрөө бас нэлээдгүй хохирол

¹³ erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiya-l-i tobčilan quriyaýsan altan tobči kemekü orusibai, Ш.Бира (1990) эрхлэн, жинхэнэ эхийг гэрэл зургаар хэвлэсэн хэвлэл, Улаанбаатар, А-156 тал.

¹⁴ Ratchnevsky (1983) P, Cinggis Khan Sein Leben and wirken, Wiesbaden, S.8.

¹⁵ Гумилев, Л.Н, Куркчи, А.Н (1990) Черная легенда, Октрытие Казани,

амсчээ. Чингис хаан Халх голруу нүүж, цэргээ тоолоход 2600 байсан гэдэг. Энэ тулааны дараа Чингис хаан Жамуха, Алтан, Хучар, Ван хан, Сэнгүм нарт тус тус дуу бариулан, элч илгээж, тэдний урваж шарвасан зан, андгай тангарагаа няцсан гутамшигт хэрэг, муу муухай ааш араншныг нь илчлэн хэлүүлдэг. Үүний дотор, Жамухад элч илгээж дуу бариулахдаа, *“Хан эцгээс минү үзэн ядаж хагацуулав, чи. Урьд боссон бидний (ману, маань) Хан эцгийн хөх чун-г уух бүлгээ. Надад урьд босч уугдруун(уугдахад) найтав (атаархав) зэ, чи. Эдүгээ Хан эцгийн хөх чун-г барадхун. Хэдий зэ, хороохун, та (та нар)?”*¹⁶ хэмээсэн байдаг. Энд Чингис хаан бээр бага насныхаа нэгэн дурсамжийг Жамухын атаарахуй занг илчлэхийн ялдамд өгүүлжээ. Энэ нь Тэмүжиний бага насны намтарт холбогдох тун сонин баримт юм. Юуны учир, хэзээ, Тоорил ханы өөрийн өргөөнд байран суурин байсан хэрэг вэ? Хэмээх асуулт аяндаа урган гарна. Чингис хааны үг нь элчид дуу бариулан хэлүүлж байгаа тул зөвхөн чи бага байхын атаач зантай гэдгийг баримтаар сануулж, бас Ван ханыг хатгаж энэ дайныг дэгдээсэн хэргийг битүүгээр өгүүлжээ. Тэмүжин Жамуха хоёр бага насандаа Тоорил ханы өргөөнд хэсэг хугацаагаар яах, юу хийх хэмээн байв гэвэл, зөвхөн бичиг үсэг сурах л гэж байсан болов уу хэмээн таамаглахаас өөр шалтаг шалтгаан үл олдоно. Есүхэй баатар өөрийн анд Тоорил ханы гэрт хүүгээ хүргэж, уйгуржин монгол бичгийг аль хэдийнэ хэрэглэж ирсэн Хэрэйдүүдийн дунд бичгийн боловсрол олгохыг зорьсон хэрэг бололтой. Хэрэйд аймгийхан бичиг үсэгтэй байсан тухайд, нэрт монголч эрдэмтэн Б.Я. Владимирцов бээр монгол бичгийн суурь болсон аялгууны тухай бичихдээ Хэрэйдийг тухайлан дурдсан билээ.¹⁷ Тэмүжин Жамуха хоёр хэзээ Тоорил ханы дэргэд, түүний аягатай айргийг өрсөлдөн ууж байв, хэмээвээс лавтай Есүхэй баатрыг амьд сэрүүн байх цаг буюу Тэмүжиний есөн наснаас өмнөх үеийн хэрэг болов уу.

Нэгэн зүйл: МНТ -ны 116-р зүйлд, *“Анх урьд анд бололцуруун, Тэмүжин арван нэгэн наст бүхүйд, Жамуха гуралтуг шаа Тэмүжинээ өгч, Тэмүжиний чингүлтүгт шаагаар, анд бололцож, анд хэмээлцсэн Ононы мөлсөнд(мөсөнд) шаалцахуйд (шагалцахуйд), тэнд анд хэмээлдээ. Түүний хойно хавар алинггар нумтан харвалдан бүхүйд, Жамуха бярууны хоёр эвэр нааж, нүхэлж, дуут ёроон Тэмүжинээ өгч, Тэмүжиний арц манлайт годилтой арилжисж андчилалдав. Нөгөөтөө анд хэмээлдсэн ёсон тийм”*¹⁸ хэмээн бичсэн нь өөрийн эрхгүй, өмнө эш татсан харийн элч төлөөлөгчийн тэмдэглэлийг бодогдуулна. МНТ -ны энэ баримт нь шагайн наадгай, мөсөн дээр шагалцах наадам бол эрт цагийн уламжлалтай хийгээд бага хөвгүүдийн харвах зүйл зүйлийн нум сум байсан гэх мэт түүхэн мэдээг агуулсны хамт, хамгийн гол нь Тэмүжин бээр 11, 12 насандаа Жамухатай анд бололцсон, Ононы мөсөн дээр наадаж тоглож явсныг өгүүлжээ. Энэ нь Тэмүжиний бага насанд холбогдох тун цөөхөн баримтын нэг билээ. Тэмүжин дүү нарын хамт загас жараахай барьж, тарвага зурам агнаж, амь зуулгадаа тус нэмэр хийхийн сацуу бас үеийн нөхөдтэйгөө, тухайлбал Жамухатай уулзаж учирдаг байсныг энэ баримт тодорхой мэдээлж байна. Өөрөөр

¹⁶ Ш. Чоймаа (2011), *(Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртоогоо) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг).* 126-р тал. Улаанбаатар.

¹⁷ Б.Я. Владимирцов (2005) “Работы по Монгольскому языкознанию” стр. 429-430, Москва.

¹⁸ Ш. Чоймаа (2011), *(Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртоогоо) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг).* 65, 66-р тал. Улаанбаатар.

хэлбэл, Өгээлүн эх хөвүүдийн хамт Тайчуудад хаягдан хоцорсон хэдий ч бас хань хамсаатан цөөнгүй байсныг үүнээс ухаарч болно.

Нэгэн зүйл: Чингис хааны намтрыг туурвигчдийн ихэнх нь МНТ-ны зүйл дугаарын дагуу бичдэг тул энэ мэт хожим хойно ташрамын үгэнд цухас цухас гарах тун чухал мэдээг урагш холбон үзсэн нь ховор ажээ. Тэмүжиний бага залуу насын тухай өгүүлэхдээ, дээр дурдсан мэт сонин баримтыг яргуулан үзье. МНТ-ны 107-р зүйлд: *"Жамухын эд үгсийг ину Хасар Бэлгүдэй хоёр ирж, Тэмүжинээ өгүүлж, Тоорил ханаа (ханд) хэл хүргэв. Тоорил хан, Жамухын эд үгсийг хүргүүлээд (энэ мэдээг аваад), хоёр түмэд морилов (хөдлөв). Тоорил хан морилруун (морилохдоо), Бурхан халдуны өвөр Хэрлэний Бүрги эрэг зорин айсуй хэмээн, Тэмүжин Бүрги эрэгт бүрүүн (байх тул) мөрт (замд) буй хэмээн зайлан, Түнхэлиг оод нүүж, Тана горхиноо, Бурхан халдуны өврөө (өвөрт) бууж, Тэмүжин тэндээс цэрэг үүсгэжсүхүй. Тоорил хан нэгэн түмэн, Тоорил ханы дүү Жаха Гамбу нэгэн түмэн, хоёр түмдээр Химурга горхины Айл харганад бууж бүхүйд нийлэн буув"*¹⁹ хэмээн гардаг. Энэ хэсгээс сонирхол татах зүйл бол *"Бурхан халдуны өврөө(өвөрт) бууж, Тэмүжин тэндээс цэрэг үүсгэжсүхүй"* хэмээсэн хэсэг юм. Боорчу, Зэлмэ хоёроос өөр нөхөдгүй байсан бол хаанаас цэрэг үүсгэх билээ?!

Энэ асуултад судлаачид янз янзаар хариулжээ. Тухайлбал, академич Ш.Нацагдорж бээр Тоорил хан, Тэмүжин, Жаха хамбу нар гурван Мэргидийг довтолохоор болзсон хугацаанаас гурван өдөр хожимдож, Жамухатай нийлэн очсон тухай өгүүлэхдээ *"Миний бодоход ийнхүү гурван өдөр болзооноос саатсан нь Тэмүжинээс болжээ. Нэг түмэн цэрэг цуглуулах нь түүнд ч хялбаргүй байсан бололтой."*²⁰ хэмээсэн бол академич Н.Ишжамц бээр *"Тэр үед Тэмүжинд өөрийн цэрэг гэж гавиатай юм байсангүй, гагцхүү Тоорил хан, Жамуха нарын их цэргийг түшиж ялалт байгуулжээ"*²¹ хэмээсэн байдаг. Судлаач Сайшаал гуай *"Тэмүжин тэндээс цэрэг үүсгэж" гэж "Нууц товчоон", "Лу.Алтан товч"-д тэмдэглэж байхыг үзэхүл, энэ үед Тэмүжин өөртөө зохих хэмжээний цэрэгтэй болжээ. Гэвч чухам хэдий цэрэгтэй байсан нь тодорхойгүй юм. Юу ч гэсэн ганц өөрийн хүчээр Мэргидтэй байлдах бололцоогүй байв. Ингээд Ван хан ба Жамухаас тусламж гуйжээ"*²² хэмээн бичжээ. Дээрх судлаачидын үзэл дүгнэлтийн нийтлэг нэг тал нь Тэмүжиний ойр тойронд зохих хэмжээний харьяат иргэд байсныг зөвшөөрсөн зүйл болно.

Нэгэн зүйл: МНТ-ны 106-р зүйлд, Жамуха өгүүлэхдээ, *"эндээс морилоруун (морилохдоо, хөдлөхдөө), Онон мөрөн өөд, энд буй андын улсаас нэгэн түм, би эндээс нэгэн түм, хоёр түм болж, Онон мөрөн өөд одож, Ботохан бооржид болзоол газраа нийлэлдье"*²³ хэмээсэн байдаг. Жамуха энэ үгийг өгүүлэх үедээ, Ононы Хорхонаг

¹⁹ Ш. Чоймаа (2011), *(Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртоогоо) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг)*. 59-р тал. Улаанбаатар.

²⁰ Ш.Нацагдорж (1991) *Чингис хааны цадиг*, 41-р тал, Улаанбаатар.

²¹ Н.Ишжамц (1974) *Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь* Улаанбаатар, 42-р тал.

²² Сайшаал зохиов. *Чингис хааны товчоон (дээд дэвтэр)*, (кирил үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа нар) (2004), 148-р тал. Улаанбаатар

²³ Ш. Чоймаа (2011), *(Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртоогоо) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг)*. 59-р тал. Улаанбаатар.

жубурт нутаглаж байжээ. Гурван Мэргидийг довтолж, Бөртэ-Үжинийг аварсны дараа Тэмүжин Жамуха хоёр мөн л Хорхонаг жубурт нийлж буудаг. Тэмүжин Жамуха хоёр жил хагас хамт байгаад нүүх үед, Жамухын салан одохоо дохиолсон ёгт үгээс шалтгаалж, тэд хагацан салдаг. Тэр үед Тэмүжиныг өдий төдий хүрээ иргэн, бүр Хиад жүрхиний гол хүмүүс Сэчэ бэхи, Тайчу нар ч Тэмүжинийг даган ирдэг. Эдгээр даган ирэгсэд бол Жамухын ойр орчимд нутаглаж байсан Тэмүжиний харьяат байх ёстой иргэд, өөрөөр хэлбэл, Жамухын үгэнд гарч байгаа "энд буй андын улс" юм. Есүхэй баатар нас барснаас хойш Тайчууд уван цуван салан одсон боловч, бас ч нилээд улс иргэн тухайлбал, Хиад жүрхинийхэн, Жалайр аймаг тэргүүтэн Тэмүжин Жамуха хоёрын ойр орчимд байсан гэдэг нь эргэлзээгүй зүйл болно. Харин МНТ-нд Тэмүжиний бага насны үеийг өгүүлэхдээ, цөөн содон зүйлийг товойлгон бичээд, нэлээдийг товчилсон ч тодорхой байдаг. Ер нь яг тухайн тэр үед хэсэг бүлгээрээ нэгэн толгойлогчийг дагалдан аж төрөн суудаг чөлөөт сул иргэд өдий төдий байсан гэдгийг санах ёстой.

Нэгэн зүйл: МНТ-ны 73-р зүйлд: Өгээлүн эх бээр "... туглаж, биеэр морилж, зарим иргэнийг няцаав"²⁴ хэмээн өгүүлсэн бол "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл"-д "... Чингис хааны эх хатан Өгээлүн хилэгнэж туг өргөн, биеэр цэрэг дайчилж урвагсадыг нэхэж, олонхыг буцааж иржээ"²⁵ хэмээжээ. Мөн Рашид-ад-дины "Судрын чуулган"-д "Чингис хаан арван гурван настайдаа, эцгээсээ хагацсан гэдгийг бид бичсэн билээ. Харин Аллахын тусламж, түүний эцэг Есүхэй баатарын үед цуглан нэгдсэн бөгөөд түүнд дуулгавартай байсан олон аймаг нь Чингисийг бяцхан хүүхэд байсан болохоор тарж одох болсон байна. Харин түүний Үүлэн эх (Өүлэн эх) нь ихээхэн авьяаслаг бөгөөд ухаантай эмэгтэй байсан болохоор тэрбээр боломжынхоо хирээр Есүхэй баатараас хойш, үлдэж хоцорсон түүний талынхан, цэргүүд захирагсад, мөн хааны эд хогшил, гэрийнхэн ба хөвүүдээ хамгаалж харж хандаж байлаа."²⁶ хэмээн бичсэн нь мөн л нэлээд иргэн улс Тэмүжиний ойр орчимд байсаар байсныг өгүүлсэн хэрэг. Есүхэй баатрыг нас барснаас хойш, түүний харьяанд байсан, ураг удмын холбоотой улс иргэд бүгд орхин одсон гэдэг үнэмшилгүй зүйл юм. Түүхч Д.Гонгор бээр, "Нууц товчооны заалтаар бол Есүхэйн захиргаанд байсан олон аймаг цөм сарнин бутарч, түүний гал голомтын дэргэд юу ч үлдээгүй мэт боловч, энэ баримт баахан эргэлзээтэй юм. Учир нь Тэмүжин Хэрэйдийн Ван хан, Жадраны Жамуха сэцэн нар анхан удаа, Мэргид аймгийг дайлахад Тэмүжин харьяат нараас түмэн цэрэг морджээ. Мөн түүнчлэн үүнээс дөнгөж хоёр жилийн дараа Тэмүжин 13 хүрээ цэрэгтэй болсон байжээ. Бидний бодоход эдгээр цэргүүд нь Есүхэйн дараа болсон Тайчууд тэргүүтэй овог аймгийн самууны үед салан одоод, дахин буцаж бөөгнөрсөн бус, анхнаасаа үлдэн хоцорсон хүмүүс байсан бололтой"²⁷ хэмээсэн нь үнэнд нийцэх буй за. Гагцхүү Тэмүжиний ойр тойронд эрт цагаас нутаглаж ирсэн Нирун-хиад удамтан л гол цөм нь байсан болов уу.

²⁴ Ш. Чоймаа (2011), (Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртоогоо) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг). 34-р тал. Улаанбаатар.

²⁵ Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл, Асралт, Хөх-Өндөр нар (1985) харгуулан орчуулав. Хөх хот, 10-р тал.

²⁶ Рашид-ад-дин, Судрын чуулган, (I боть, II дэвтэр), орчуулсан Ц.Сүрэнхорлоо (2002), 217-р тал. Улаанбаатар.

²⁷ Д.Гонгор (1970) Халх товчоон I боть, 78-р тал., Улаанбаатар.

Хатуужлыг үзэж, хат суусан үе

МНТ-ны баримтаар бол, Тэмүжин бага залуу насандаа гурван удаа аюул түгшүүрт учирсан юм. Анхных нь Есүхэй баатар нас бараад 7 жил болсон хойно 1177 онд Тайчууд аймгийн гэнэтийн дайралтад өртөж баригдсан.²⁸ Энэ үед өөрийн арга ухаан, шийдмэг зоригоор оргон нуугдаж, Сорхон шар болон тэдний гэрийнхний халуун тус дэмээр дайснаас мултарч чаддаг. Энэ үйл явдлаас Тэмүжин дараах сургамжийг олж авсан юм.

1. Эгзэгтэй мөчийн өчүүхэн боломжийг алдалгүй ашиглаж чадвал амиа ч аварч болно гэдгийг ухаарсан.
2. Хөнөөх сэтгэлтэн байхад, туслах хүмүүс бас байдаг. Дайсан дотор ханилах, дагах нөхөд бий гэдгийг мэдэрсэн.
3. Энэ үеэс ачийг үл мартахыг нэгэн насандаа мөрдлөг болгосон. Тухайлбал, 1206 онд Их Монгол Улсыг байгуулаад, гавьяатанд шан хэшиг хүртээх үедээ Сорхон шард хандаж,

“Тэр тус сайныг тану сэтгэж

Хар шөнө зүүдэнд

Гэгээн өдөр цээжинд

Сэтгэж явав зэ, би”²⁹

хэмээгээд түүний хүслээр нутаг дархлан өгч, есөн гэм хийвээс үл хэрэгсэх болгосон билээ. Ийм баримт олон бий.

Тэмүжиний бага залуу насанд хоёр дахь удаа учирсан аюул бол шарга агттай найман морио дээрэмдүүлсэн хэрэг бөгөөд дүү нараа хайрлаж, ганцаар дээрэмчний мөр мөшгин хөөх үед хээр хөдөө үл таних Боорчу хэмээх залуу уулзаж, түүний тусламжтайгаар морьдоо дээрэмчдээс булааж авчирдаг. Энэ хэрэг Тэмүжинд том сургамж болж, бас Тэмүжиний зан төрхийн хэдэн талыг илтгэн харуулсан юм.

Арулад овгийн Наху баяны ганц хүү Боорчу Тэмүжиний учир явдлыг сонсоод, гэртээ ч харилгүй, *“Эр хүний мун (зовлон) нэгэн буй за. Би чамд нөхөцсү”* хэмээн унасан морийг нь сольж өгөөд, хамт гурван хоног довтолгож, дээрэмчний хүрээнээ хүрдэг. Тэмүжин: *“Нөхөр чи энд бай! Би тэд буй шарга агттаныг үлдэж гарсугай”* хэмээхэд Боорчу: *“нөхөцсү (нөхөр больё) хэмээн ирлээ би. Энд яахин байх”* хэмээгээд адуугаа хөөн гардаг. Дээрэмчид хойноос хөөж ирэхэд, Боорчу, *“Нөхөр, нум сумаа надад ац. Би харвалдсу”* хэмээн хэлэхэд, Тэмүжин, *“Миний өмнөөс чи эрсдүүзэй. Би харвалалдсу”* хэмээж, гэдрэг эргэж харвалддаг. Тэмүжин, Боорчу хоёр гурван өдөр, гурван шөнө зогсолтгүй явах замдаа Тэмүжин, *“Нөхөр, би чамаас ангид эд морьдоон авах юу бүлгээ. Хуваалдъя. Хэдийг авах хэмээмүй?”* хэмээхэд, Боорчу *“Би сайн нөхөр чамайг мунтанаж (бэрхдэж) айсуй хэмээн сайн нөхрөө (нөхөрт) тус болсу хэмээн нөхөцөж*

²⁸ Сайшаал, *Чингис хааны товчоон*, дээд дэвтэр, (Кирилл үсэгт хөрвүүлсэн Ш. Чоймаа) (2004) нар, 107-р тал., Улаанбаатар.

²⁹ Ш. Чоймаа (2011), *(Хянан тохиолдуулсан, академич Д. Төмөртөгов) Монголын Нууц Товчоон, (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай ийнэ хөрвүүлэг)*. 81-182-р тал., Улаанбаатар 6

ирэв би. Олз хэмээн авах уу би? Эцэг минү Наху баян нэрт буюу. Наху баяны гагц хөвгүүн би буюу. Эцгийн минү зөөсөн над түгтэл буюу (надад хүрэлцэхүйц буй). Би үл авах. Тус болсон мину юун тус болох, үл авах”³⁰ хэмээгээд, гэртээ ирж, хоол хүнс төхөөрч явуулдаг.

Энэ үйл явдлаас үзэхэд, Тэмүжин дүү нараа ч, шинэ учирсан нөхрөө ч амь алдах аюулд үл оруулах зөөлөн сэтгэл, бат журмыг сахигч байсан нь харагдана. Нөгөө талаас, нөхөрлөсөн анддаа чин үнэнч Боорчугийн хэлсэн үг, хийсэн хэрэг нь цөм Тэмүжиний зүрх сэтгэлд шингэж, өөрийн үе тэнгийн эрэмгий дайчин, нэгэн сэтгэлт үл таних залуу эр өөрийг нь тоож, үнэнчээр тусалсан нь Тэмүжинд их урам зориг өгчээ. Өөрөөр хэлбэл, олзны төлөө бус, нөхөрлөлийн төлөө үнэнч зүтгэх Боорчу-г олсон нь Тэмүжинд асар ихийг ойлгуулж, ирээдүйн шадар жанжид, баатар эрсээ сонгох гол баримтлал болсон билээ. “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэдэг монгол сургамжийг Тэмүжин биеэрээ мэдрэв.

Хожим Чингис хаан 1206 онд Их Монгол Улсын хаан болж, гавьяатныг томилохдоо, Боорчу-гийн их ач тус, гавьяа зүтгэлийг өчүүхэн ч гээлгүй дурдаж, Баруун гарын Алтайн түмнийг захирах ноён болгож томилсон билээ.

15, 16 орчим настай Тэмүжин хүү Монголын тал нутагт үнэн шударга сэтгэлт, эрэлхэг дайчин, эелдэг тусч эр нөхөр байхыг биеэр мэдрч, ийм хүмүүсийг өөртөө татаж нөхөрлөвөл их хэрэг бүтээж болохыг бүрэн ойлгожээ. Бас өөрийн эр чадлыг анх удаа шалгасан бөгөөд өөрийн хүчиндээ итгэх итгэл зориг нэмэгдсэн аж. Чингис хаан насан туршдаа Боорчу шиг үнэнч шударга сэтгэлтнийг хүндэтгэн дээдлэх болсон нь энэ цаг үеэс эхлэлтэй бөгөөд түүний амьдралдаа баримталсан энэ зарчим гайхамшигт амжилт олохын гол үндэс болсон юм.

Тэмүжиний бага залуу насанд тохиолдсон гурав дахь аюул бол мэргидүүд гэнэт довтолж хатан Бөртэ үжинийг булаан авч одсон хэрэг юм. 1178 оны орчим буюу Тэмүжиний 17 настай байх үед энэ хэрэг болсон бололтой.

Энэ явдал нь итгэлт нөхдийг өөртөө татах төдийгүй бусад аймаг улстай холбоо тогтоохын чухлыг Тэмүжинд ойлгуулав. Тэмүжин ч эцгийн анд Тоорил ханаас тусламж гуйж, Тоорил хан, Жамуха, Тэмүжин гурав хамтарч Гурван Мэргидийг дарж хатан Бөртэ үжинээ авардаг билээ. Монголын тал нутагт харилцан булаалдан, харилцан дайсагналцаж байдаг олон аймаг улсын утга учиргүй тэмцлийг зогсоохын тулд тархай бутархай улс аймгуудыг нэгэн эрхэнд хураан нэгтгэхээс өөр аргагүй юм гэсэн холын санаа залуу Тэмүжинд төлөвшиж эхэлжээ.

Мөн энэ үед Тэмүжин бээр анхны хүүхэд, нуган үрийн зулайг үнэрлэж, аав хэмээх алдрыг хүлээх болсон нь баяр баясал төдийгүй бие хүний төлөвшилд зохих ёсоор нөлөөлсөн билээ. Зайлшгүй цохон тэмдэглэх ёстой нэг зүйл бол, Тэмүжиний ууган хүү Жочийг түүх, уран зохиол тэргүүтэнд гажуудуулан өгүүлсэн нь олонтаа буй. Үүний уг шалтгаан нь МНТ-ны хятад эхэд, Цагаадайн хэлсэн үгэнд гарах "chu-l(e)-wu-l(e)-cha-wu-ra" хэмээсэн үгээс үүджээ. Энэ нь монгол үгийг хятадаар галигласан зүйл бөгөөд хажуугийн хятад орчуулга байдаггүй тул судлаачид янз бүрийн таавар үг

³⁰ Мөн номын 44-46-р тал.

оноожээ. Тэр нь "чул олзуур" хэмээсэн үг. Утга нь, цочмог түргэн зантай Цагаадай бээр ах Жочийг муутган өгүүлэхдээ, чи ээжийн гэдсэнд байхдаа дайсны олз байсан хүн шүү дээ хэмээн доромжилжээ. Тийм ч учраас л Хөхөчос Өгээлүн эхийг гомдоолоо хэмээн машид хатуу зэмлэсэн хэрэг. Энэ тухай профессор А.Цанжидын "Жочи Чингисийн төрсөн үр мөн"³¹ хэмээх өгүүлэлдээ бодот баримтыг тодорхой бичсэн буй.

Ийнхүү Тэмүжин бага залуу насандаа гурван удаагийн аюул (*Рашид-ад-диний бичсэнээр гурав бус олон удаагийн аюул осол*), хатуу сорилыг давж, өөртөө итгэх итгэл олж, өвөг дээдсийнхээ их үйлсийг сэргээх хатуу чанга зоригтой болж, талын язгууртнуудаас илүү холыг харж, өөрийг нь тойрон хүрээлэх, даган ирэх холбоотонтой болж эхэлсэн байна.

Эцэг Есүхэй баатар нас барснаас хойш үргэлжийн зовлон бэрхшээл, аюул түгшүүрийн дунд 10 шахам жилийг өнгөрөөсөн нь амьдралын том сургамж болсон төдийгүй ирээдүйн Чингис хаан хэмээх бие хүний гол гол зан төрх, амьдралдаа баримтлах зарчмын үндэс нь бүрэлдэн буй болжээ.

РЕЗЮМЕ

Автор в своей статье освещает некоторые аспекты жизни и личности Чингис хаана (собственное имя Тэмуджин) основателя и первого великого хаана-полководца Монгольской империи, объединившего разрозненные монгольские племена и покорившего многие народы. При этом автор опирается на фактический материал из известных исторических источников, в которых содержится характеристика его личных качеств, таких как выдающиеся организаторские способности, непреклонная воля и самообладание.

³¹ Монгол судлал МУИС-МХХС-ийн эрдэм шинжилгээний бичиг XXXI, // , (2010), 198-204-р хуудас, Улаанбаатар.,